



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/120/СТА-ТШЗ



Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576 Цахим хаяг: munkhbat.B@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 70442424, 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Ахлах аудитор: А.Цээням

Утас: 99442140, 88011833 Цахим хаяг: tseenyam.A@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
	байхгүй	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
3.4	АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	15
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР СУМЫН ЭРДЭНЭМАНДАЛ
АХЛАХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.ЭНХТӨР ТАНАА

2019.02.18 № 2/23
танай _____-ны № _____-т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох

2019 on gerchilgee_Erdenemandal ahlah surguuli .docx

2519011

бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал Ц.Энхтөрт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох талаар саналаа тухай бүр нь нягтлан бодогчид өгсөн болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.13-наас 2019.02.16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор А.Цээням хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.23-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургууль нь “Боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсролыг сурагчдад эзэмшүүлэн, суралцагчдын хөгжлийн төлөө багш, эцэг эх хамтран ажиллах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тайлант хугацаанд Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургууль “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 2.1-т заасны дагуу ерөнхий боловсролын суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд сургалтын үйл ажиллагаагаа чиглүүлж, сургалт хүмүүжлийн ажлыг төлөвлөх, бэлтгэх, зохион байгуулах, үнэлэх ажлыг хамтын оролцоотой хэрэгжүүлэх 9 зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс

үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн тооцоолох программ” хангамж ашиглаж, цалингийн тооцоололыг “Payroll 2018” цалингийн программ ашиглан гүйцэтгэсэн байна.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, гүйцэтгэлийн шатанд 2 эрсдэл нэмж тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1546310,2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 15463,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Аудитын явцад хийсэн мэдээллийг В30102 маягтаар нэгтгэж, баримтжуулсан. Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд тусгай зориулалтын шилжүүлгээр 1453019,6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдаж бүрэн авч, оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 42,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 73 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайланд зөвлөмж өгөгдөөгүй.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

СТ-1А

төгрөг

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>127,495,371.16</u>	<u>146,640,057.22</u>
33	АВЛАГА	00.00	1,414,133.56
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	275,546.56
335	Бусад авлага	00.00	1,138,587.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,138,587.00
35	БАРАА МАТЕРИАЛ	127,495,371.16	145,225,923.66
351	Түүхий эд материал	15,245,584.74	16,302,176.64
35110	Тусгай зориулалттай материал	14,830,734.74	15,902,326.64
35130	Эм боох материал	414,850.00	399,850.00
354	Хангамжийн материал	112,249,786.42	128,923,747.02
35410	Бичиг хэргийн материал	3,846,500.00	5,187,610.00
35420	Аж ахуйн материал	4,455,080.00	4,788,434.00
35440	Түлш, шатах тослох материал	70,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	7,515,812.00	8,545,332.00
35470	Бусад хангамжийн материал	96,362,394.42	110,402,371.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,424,083,891.27</u>	<u>3,887,390,718.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,424,083,891.27	3,887,390,718.38
392	Биет хөрөнгө	2,424,083,891.27	3,251,940,718.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,839,526,146.00	3,125,684,656.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-590,808,476.66	-16,085,298.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	217,161,223.95	207,417,363.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	-149,994,830.39	-163,923,484.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	139,535,819.75	155,867,074.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	-97,686,137.30	-105,590,592.01
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,366,160.00	00.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,110,697.08	00.00
39217	Ном	45,094,683.00	48,570,998.00
393	Биет бус хөрөнгө	00.00	635,450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,050,000.00	640,500,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-5,050,000.00	-5,050,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,551,579,262.43</u>	<u>4,034,030,775.60</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,551,579,262.43</u>	<u>4,034,030,775.60</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,551,579,262.43	4,034,030,775.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	833,160,681.55	1,468,610,681.55
51101	Өмч: - төрийн	833,160,681.55	1,468,610,681.55
512	Хуримтлагдсан үр дүн	-212,540,433.41	530,650,450.00
51210	Өмнөх үеийн үр дүн	-212,540,433.41	-212,540,433.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	743,190,883.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,930,959,014.29	2,034,769,644.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,551,579,262.43</u>	<u>4,034,030,775.60</u>

3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

СТ-2А

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,696,953,672.00	2,289,501,121.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,718,388.00	798,677,106.60
120	Нийтлэг татварын бус орлого	9,718,388.00	798,677,106.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,718,388.00	798,677,106.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,502,909.00	1,175,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,215,479.00	797,502,106.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	148,681,684.00	37,804,415.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,538,553,600.00	1,453,019,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,538,629.00	15,126,337.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,538,629.00	15,126,337.00
1330	Төсвийн захирагчдаас	124,973,426.00	00.00
133003	Хөрөнгийн	124,973,426.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,169,629.00	22,678,078.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	17,169,629.00	22,678,078.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,647,966,559.18	1,546,009,873.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,647,966,559.18	1,546,009,873.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,355,591,313.81	1,448,718,810.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	865,530,631.00	873,051,369.00
210101	Үндсэн цалин	700,756,031.00	679,111,814.00
210102	Нэмэгдэл	105,132,600.00	133,685,116.00
210104	Урамшуулал	59,642,000.00	60,254,439.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,100,642.63	105,815,572.44
210201	Тэтгэврийн даатгал	96,100,642.63	71,277,343.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	9,015,430.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	6,527,098.91
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,726,883.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	17,268,817.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	269,422,136.00	326,261,910.14
210301	Гэрэл, цахилгаан	9,282,340.00	10,852,806.00
210302	Түлш, халаалт	224,188,684.00	259,332,468.14
210303	Цэвэр, бохир ус	35,951,112.00	56,076,636.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,390,683.50	16,549,608.60
210401	Бичиг хэрэг	3,694,950.00	5,531,830.00
210402	Тээвэр, шатахуун	1,870,800.00	2,011,939.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,190,073.00	4,436,299.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,627,760.00	2,812,834.00

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210408	Бараа материал акталсны зардал	5,007,100.50	1,756,706.10
2105	Нормативт зардал	231,350.00	343,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	231,350.00	343,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,683,400.00	13,261,845.00
210604	Урсгал засвар	4,683,400.00	13,261,845.00
2107	Томилолт, зочны зардал	1,664,500.00	993,900.00
210702	Дотоод албан томилолт	1,664,500.00	993,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,832,500.00	2,565,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,832,500.00	2,565,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,735,470.68	109,876,155.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,645,700.00	4,443,123.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	2,730,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	96,789,770.68	102,703,032.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	292,375,245.37	97,291,063.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	290,452,835.00	97,248,978.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	17,169,629.00	22,678,078.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,792,500.00	53,632,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,417,406.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	141,893,300.00	20,292,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,180,000.00	646,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,922,410.37	42,085.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,922,410.37	42,085.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>48,987,112.82</u>	<u>743,491,247.73</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	300,364.32
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	300,364.32
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-300,364.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>48,987,112.82</u>	<u>743,190,883.41</u>

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,563,764,767.00</u>	<u>1,491,999,015.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>1,502,909.00</u>	<u>1,175,000.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	1,502,909.00	1,175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,502,909.00	1,175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,502,909.00	1,175,000.00

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,562,261,858.00	1,490,824,015.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,538,553,600.00	1,453,019,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,538,629.00	15,126,337.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,538,629.00	15,126,337.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,169,629.00	22,678,078.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	17,169,629.00	22,678,078.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,563,764,767.00	1,491,999,015.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,563,764,767.00	1,491,999,015.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,271,389,521.63	1,393,569,364.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	866,330,237.00	869,990,488.00
210101	Үндсэн цалин	701,555,637.00	681,535,088.00
210102	Нэмэгдэл	105,132,600.00	122,357,700.00
210104	Урамшуулал	59,642,000.00	66,097,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,301,036.63	109,152,000.00
210201	Тэтгэврийн даатгал	60,664,836.63	72,555,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,950,000.00	9,148,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,651,700.00	7,319,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,703,700.00	1,829,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,330,800.00	18,298,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	270,102,136.00	326,407,410.14
210301	Гэрэл, цахилгаан	9,962,340.00	10,998,306.00
210302	Түлш, халаалт	224,188,684.00	259,332,468.14
210303	Цэвэр, бохир ус	35,951,112.00	56,076,636.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,760,983.00	15,012,991.50
210401	Бичиг хэрэг	2,038,670.00	3,442,260.00
210402	Тээвэр, шатахуун	1,940,800.00	1,941,939.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,190,073.00	4,285,149.50
210404	Ном, хэвлэл	1,007,200.00	1,595,955.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,584,240.00	3,747,688.00
2105	Нормативт зардал	1,238,900.00	593,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	351,400.00	209,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	887,500.00	383,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,748,400.00	21,312,995.00
210604	Урсгал засвар	4,748,400.00	21,312,995.00
2107	Томилолт, зочны зардал	1,664,500.00	993,900.00
210702	Дотоод албан томилолт	1,664,500.00	993,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,062,500.00	2,903,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,062,500.00	2,903,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,180,829.00	47,202,930.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,780,829.00	27,848,450.00

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	19,354,480.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	292,375,245.37	98,429,650.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	290,452,835.00	97,248,978.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	17,169,629.00	22,678,078.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,792,500.00	53,632,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,417,406.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	141,893,300.00	20,292,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,180,000.00	646,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,922,410.37	42,085.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,922,410.37	42,085.36
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,138,587.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,138,587.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
СТ-4А

төгрөг

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	833,160,681.55	1,930,959,014.29	-212,540,433.41	2,551,579,262.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	833,160,681.55	1,930,959,014.29	-212,540,433.41	2,551,579,262.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	103,810,629.76	00.00	103,810,629.76
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	635,450,000.00	00.00	743,190,883.41	1,378,640,883.41
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	530,650,450.00	4,034,030,775.60

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

төгрөг

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,402,606,200.00	1,392,985,771.00	1,454,194,600.00	1,454,152,514.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,402,606,200.00	1,392,985,771.00	1,454,194,600.00	1,454,152,514.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,288,371,200.00	1,280,191,527.00	1,379,622,400.00	1,379,581,614.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	935,680,100.00	927,753,796.24	870,021,400.00	869,990,488.00
210101	Үндсэн цалин	711,262,000.00	703,335,706.24	681,566,000.00	681,535,088.00
210102	Нэмэгдэл	171,749,800.00	171,749,790.00	122,357,700.00	122,357,700.00
210104	Урамшуулал	52,668,300.00	52,668,300.00	66,097,700.00	66,097,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,924,900.00	102,924,900.00	109,152,000.00	109,152,000.00
210201	Тэтгэврийн даатгал	65,497,700.00	102,924,900.00	72,767,904.00	72,555,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,485,400.00	00.00	9,095,963.00	9,148,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,356,800.00	00.00	7,276,890.00	7,319,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,871,400.00	00.00	1,819,272.00	1,829,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,713,600.00	00.00	18,191,971.00	18,298,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,363,900.00	216,022,567.76	326,407,500.00	326,407,410.14
210301	Гэрэл, цахилгаан	6,739,600.00	7,118,539.00	11,489,000.00	10,998,306.00
210302	Түлш, халаалт	171,501,800.00	177,068,863.76	258,887,000.00	259,332,468.14
210303	Цэвэр, бохир ус	38,122,500.00	31,835,165.00	56,031,500.00	56,076,636.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,130,400.00	10,189,263.00	15,022,300.00	15,012,991.50
210401	Бичиг хэрэг	1,542,500.00	1,878,170.00	3,237,900.00	3,442,260.00
210402	Тээвэр, шатахуун	1,314,900.00	1,375,800.00	1,943,000.00	1,941,939.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,231,400.00	1,529,193.00	4,497,700.00	4,285,149.50
210404	Ном, хэвлэл	2,035,600.00	2,002,000.00	1,596,000.00	1,595,955.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,006,000.00	3,404,100.00	3,747,700.00	3,747,688.00
2105	Нормативт зардал	2,663,100.00	2,663,100.00	593,900.00	593,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	271,400.00	407,300.00	210,000.00	209,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,391,700.00	2,255,800.00	383,900.00	383,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,049,400.00	6,049,400.00	21,313,000.00	21,312,995.00
210604	Урсгал засвар	6,049,400.00	6,049,400.00	21,313,000.00	21,312,995.00
2107	Томилолт, зочны зардал	1,556,500.00	1,604,000.00	993,900.00	993,900.00
210702	Дотоод албан томилолт	1,556,500.00	1,604,000.00	993,900.00	993,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,458,300.00	1,456,900.00	2,903,200.00	2,903,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,458,300.00	1,456,900.00	2,903,200.00	2,903,200.00

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11544600.00	11527600.00	33215200.00	33215180.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,544,600.00	11,527,600.00	13,860,700.00	13,860,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	19,354,500.00	19,354,480.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	114235000.00	112794244.00	74572200.00	74570900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,235,000.00	112,794,244.00	74,572,200.00	74,570,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,916,100.00	42,916,100.00	53,633,500.00	53,632,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,852,100.00	49,414,344.00	00.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	19,423,800.00	19,423,800.00	20,292,700.00	20,292,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,043,000.00	1,040,000.00	646,000.00	646,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,403,781,200.00	1,394,030,598.00	1,454,194,600.00	1,454,152,514.64
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,402,606,200.00	1,392,985,771.00	1,453,019,600.00	1,452,977,514.64
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,402,606,200.00	1,392,985,771.00	1,453,019,600.00	1,452,977,514.64
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,175,000.00	1,044,827.00	1,175,000.00	1,175,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,175,000.00	1,044,827.00	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	1,175,000.00	1,175,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	113	113	103	105
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	92	92	82	84
620003	Үйлчлэх ажилтан	21	21	21	21
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,252	1,210	1,381	1,168
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬДСУРАЛЦАГЧИД	1,252	1,210	1,381	1,168
630001	Төрийн өмчит ЕБС	1,252	1,210	1,381	1,168
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	113	113	104	106
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	87	87	77	79
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26	26	27	27